


ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

10.26 - 10.30



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ: Энэ долоо хоногт АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотой тодорхойгүй байдал болон коронавирусын халдвар дахин нэмэгдэж эхэлсэнтэй холбоотой хөрөнгийн зах зээлийн индексүүд 3-р сараас хойших хамгийн их бууралтыг үзүүлжээ. S&P 500 индексийн сагсанд багтах мэдээлэл технологийн болон өргөн хэрэглээний бус бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч компаниудын хувьцаа хамгийн их бууралттай байсан бол ус, цахилгаан, дулааны салбар, барилгын материалын салбар болон үл хөдлөх хөрөнгийн салбарын компаниуд харьцангуй тогтвортой байлаа.

Коронавирусын тохиолдол огцом нэмэгдэж байгаа болон сонгуулиас өмнө эдийн засгийг дэмжих хөтөлбөр хэрэгжих боломжгүй болж байгаатай холбоотой энэ долоо хоногийг хөрөнгийн зах зээлийн индексүүд уналттай эхлүүлжээ. Мягмар гарагт АНУ-ын нийслэл болон 32 мужид коронавирусын тохиолдолтой холбоотой хэвтэн эмчлүүлэгчдийн тоо 10%-аар өссөн нь хөрөнгийн зах зээлийн индексүүд цааш унахад хүргэжээ. AstraZeneca-аас боловсруулж буй вакцин нь өндөр настнуудын дархлааны хариу үйлдлийг дэмжиж байгаа үр дүнг танилцуулсан ч коронавирусын тохиолдлын тоо хурдацтай нэмэгдэж байгаа нь вакцины тухай эерэг мэдээний нөлөөг буруулсан байна.

Европ: Коронавирусын халдварын тоог хязгаарлах зорилготой авч буй арга хэмжээнүүд Евробүсийн улсуудын эдийн засагт сөргөөр нөлөөлөн хямралд орох боломжтой байгаатай холбоотой Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд энэ долоо хоногт уналттай хаагдлаа. STOXX Europe 600 индекс 5.56%-аар, DAX индекс 8.61%-аар, CAC 40 индекс 6.42%-аар, FTSE MIB индекс 6.96%-аар, FTSE 100 индекс 4.83%-аар тус тус буурсан байна.

Евробүсийн гол бондын өгөөжүүд энэ долоо хоногт бууралттай байлаа. Өсөн нэмэгдэж буй коронавирусын халдвартай тэмцэх зорилгоор ХБНГУ болон Франц улс хөл хорио дахин тогтоосонтой холбоотой ХБНГУ-ын 10 жилийн хугацаатай ЗГҮЦ-ны өгөөж буурчээ. Пүрэв гарагт зохион байгуулагдсан бодлогын уулзалтын дараа Европын Төв Банкнаас хийсэн мэдэгдлүүд мөн үнд нөлөөлж, Евробүсийн үндсэн бондын өгөөжийг бууруулахад нөлөөлжээ.

Япон: Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд энэ долоо хоногт бууралттай хаагдлаа. Nikkei 225 индекс 539 нэгжээр буюу 2.29%-аар бууран 22,977.13 нэгж хүрсэн нь энэ оны эхэн үетэй харьцуулахад 2.9%-аар буурсан үзүүлэлт болсон байна. Япон улсын хөрөнгийн зах зээлийг бүхэлд нь илтгэдэг large-cap TOPIX болон TOPIX small индексүүд мөн бууралттай байжээ. Энэхүү уналт нь АНУ, Европын орнуудад коронавирусын тохиолдол нэмэгдэж байгаа болон Пүрэв гарагийн сүүлээр гаргасан улирлын тайлангууд хөрөнгө оруулагчдын хүлээлтэд хүрээгүйтэй холбоотой байлаа.

БНХАУ: Энэ долоо хоногт БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд дэлхийн бусад индексүүдийн адилаар уналттай байлаа. Shanghai Composite индекс 1.6%-аар, large-cap CSI индекс 0.5%-аар тус тус буурсан бол БНХАУ-ын 10 жилийн хугацаатай ЗГҮЦ-ны өгөөж 3.2% орчимд тогтвортой байлаа. Валютын зах зээл дээр Хятадын Ардын Банк дотоодын банкнуудаас юанийн дундаж ханшийг тогтвортой байлгах зорилгоор ашиглагддаг "мөчлөгийн эсрэг хүчин зүйл"-ийн хэрэглээг зогсоохыг хүссэн тухай Reuters агентлаг мэдээлэв.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	17,406.44	0.06% ▲
Dow Jones	АНУ	26,501.60	-6.47% ▼
S&P 500	АНУ	3,269.96	-5.64% ▼
Nasdaq	АНУ	10,911.59	-5.51% ▼
S&P/TSX	Канад	15,580.64	-4.44% ▼
FTSE 100	Их Британи	5,577.27	-4.83% ▼
S&P/ASX 200	Австрали	5,927.60	-3.88% ▼
Nikkei 225	Япон	22,977.13	-2.29% ▼
Hang Seng	Хонг Конг	24,107.42	-3.26% ▼

Бонд	Валют	Купон	Өгөөж
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	4.07%
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	3.72%
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	3.60%
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	1.88%
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	1.11%
DBM' 2023	USD	7.250%	5.21%
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	11.69%
Mongol 2026 (Номад)	USD	5.125%	4.36%

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.140	-0.10 ▼
Libor 3M	0.216	0.00 ▼
Libor 6M	0.242	-0.03 ▼
Libor 1YR	0.330	-0.02 ▼
US 2YR Bond	0.153	0.02 ▲
US 3YR Bond	0.191	-0.01 ▼
US 5YR Bond	0.375	0.04 ▲
US 10YR Bond	0.859	0.05 ▲

Валютын ханш	2020.10.30	Өөрчлөлт
USD	2,851.99	-0.01% ▼
CNY	425.88	-0.41% ▼
EUR	3,329.84	-1.35% ▼
RUB	35.95	-3.80% ▼
KRW	2.51	-0.79% ▼
JPY	27.33	0.22% ▲
CAD	2,139.21	-1.56% ▼

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,878.81	-1.22% ▼
Мөнгө /спот/	USD/t oz.	23.66	-3.86% ▼
Зэс	USD/lb.	304.75	-2.60% ▼
Нүүрс	USD/MT	59.17	1.11% ▲
WTI газрын тос	USD/bbl.	35.79	-10.19% ▼
Brent газрын тос	USD/bbl.	37.46	-10.32% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020.IX	1.70%
Бодлогын хүү	2020.IX	8.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020.IX	8.22%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020.IX	10.75%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020.IX	3.76%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020.IX	16.91%
Зээлийн дундаж хүү /валют/	2020.IX	10.46%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 52 компанийн 772.9 сая төгрөгийн 6,961,322 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Мерекс” /MSE: MRX/ компанийн хувьцаа 46.15%-аар буюу хамгийн ихээр өсөж 19.00 төгрөг хүрч хаагдсан бол “Монгол нэхмэл” /MSE: MNH/ компанийн хувьцаа 14.24%-аар буурч 1,801.00 төгрөгт хүрч хаагдлаа.

Компанийн бондын хоёрдогч зах зээл дээр “Лэндмн ББСБ” ХК-ийн 4.9 сая төгрөгийн 49 ширхэг үнэт цаас арилжаалагдав.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

10-р сарын 30-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,564.1 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 индекс 17,406.44 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.06% -аар өссөн байна.



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн тойм	Дүн (сая.төг)	
Арилжигдсан үнийн дүн	5,527.8	
Зах зээлийн үнэлгээ	2,564,144.8	

Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	17,406.44	0.06% ▲
MSE I индекс	7,973.53	0.06% ▲
MSE II индекс	7,263.94	-2.41% ▼

Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Үндэсний хувьчлалын сан	2,003,967	215,105,700
Ард кредит ББСБ	2,920,746	186,949,839
Ард санхүүгийн нэгдэл	86,899	117,891,631
Улсын их дэлгүүр	25,969	36,094,089
Айтүүлс	405,885	30,464,612

Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Мерекс	19.00	46.15% ▲
Хөдөөгийн тээвэр	5,250.00	14.13% ▲
Баянгол зочид буудал	28,680.00	11.60% ▲
Багануур	1,098.00	9.80% ▲
Улсын их дэлгүүр	1,309.00	8.99% ▲

Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Монгол нэхмэл	1,801.00	-14.24% ▼
Гутал	17,100.00	-13.64% ▼
Женко тур бюро	74.00	-13.53% ▼
Монгол шевро	1,200.00	-12.09% ▼
Могойн гол	6,200.00	-11.30% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК	Дүн (төг)
Ард Секюритиз	719,898,072
Ард Капитал Групп	191,711,206
БиДиСек	122,030,313
Гаули	111,457,448
Стандарт инвестмент	93,725,569

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	33Ү (сая.төг)
АПУ	568.37	604,848.87
Таван толгой	5,790.00	304,931.51
МИК холдинг	11,000.00	227,802.52
Инвескор ББСБ	2,914.00	209,015.15
Говь	196.29	153,128.28

Компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаа

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	LNBO-BD-19/06/21-C0008-17	49	4,900,600	100,030	100,000	52	17%

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	СИМБОЛ	КОМПАНИЙН НЭР	2019 ОНЫ ЦЭВЭР АШИГ /САЯ ТӨГ/	НИЙТ ХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ /САЯ ТӨГ/	НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТИЙН ХАРЬЦАА	НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /ТӨГ/	БҮРТГЭЛИЙН ӨДӨР	ХУВААРИЛАХ ӨДӨР
1	APU	АПУ	74,411.5	75,471.2	101.4%	71.0	2020.02.14	2020.05.28-НД ОЛГОВ
2	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	5,820.3	2,497.2	42.9%	4.0	2020.04.01	2020.06.29-НД ОЛГОВ
3	GTL	ГУТАЛ	2,403.7	2,436.0	101.3%	1,520.0	2020.03.13	2020.05.05-НЫ ӨДӨР
4	LEND	ЛЭНДМН ББСБ	4,910.2	1,200.0	24.4%	1.5	2020.02.25	2020.04.30-НД ОЛГОВ
5	ADB	АРД КРЕДИТ ББСБ	2,369.4	1,184.7	50.0%	4.2	2020.04.08	2020.04.29-НД ОЛГОВ
6	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	3,404.8	1,000.0	29.4%	35.0	2020.04.07	2020.06.30-НД ОЛГОВ
7	TUM	ТҮМЭН ШУВУУТ	3,232.9	960.0	29.7%	4.8	2020.04.07	2020.06.30-НД ОЛГОВ
8	AIC	АРД ДААТГАЛ	1,718.7	850.0	49.5%	34.0	2020.04.09	2020.06.30-НЫ ДОТОР
9	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	1,253.8	799.9	63.8%	10.0	2020.03.27	2020.06.30-НЫ ДОТОР
10	TEX	ТЕХНИК ИМПОРТ	2,718.2	723.4	26.6%	500.0	2020.03.01	2020.08.06-НД ОЛГОВ
11	BUK	УЛААНБААТАР БУК	2,465.3	526.2	21.3%	4.0	2020.03.30	2020.07.09-НД ОЛГОВ
12	MMX	МАХИМПЕКС	819.3	456.1	55.7%	120.0	2020.04.03	2020.10.01-ЭЭС
13	MFC	МОНОС ХҮНС	761.9	408.9	53.7%	1.0	2020.03.11	2020.09.07-НД ОЛГОВ
14	DSS	ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦТС	581.8	391.8	67.3%	37.7	2020.03.20	2020.09.02-НЫ ӨДӨР
15	MNP	МОНГОЛ ШУУДАН	1,103.6	331.1	30.0%	3.3	2020.04.05	2020.07.30-НД ОЛГОВ
16	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	820.0	322.0	39.3%	4.1	2020.02.28	2020.04.16-НД ОЛГОВ
17	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,327.6	230.8	9.9%	210.0	2020.02.25	2020.09.30-ААС
18	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,456.0	230.3	9.4%	225.0	2020.02.18	2020.06.20-ООС
19	MBW	МОНГОЛ БАЗАЛТ	335.0	225.7	67.4%	4.0	2020.03.09	2020.07.03-НД ОЛГОВ
20	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	2,117.8	152.3	7.2%	360.0	2020.04.05	2020.09.01-НИЙ ӨДӨР
21	BDS	БИДИСЕК	19.9	136.9	687.0%	10.0	2020.03.09	2020.12.31-НЫ ДОТОР
22	EER	АРИГ ГАЛ	225.8	131.0	58.0%	38.9	2020.03.27	2020.07.08-НД ОЛГОВ
23	TAN	ТАХЬКО	489.0	128.5	26.3%	108.0	2020.04.10	2020.05.04-НД ОЛГОВ
24	UBH	УЛААНБААТАР ХИВС	298.8	121.4	40.6%	300.0	2020.03.06	2020.04.17-НД ОЛГОВ
25	HRD	ХҮРД	722.6	72.4	10.0%	535.0	2020.03.02	2020.06.30-НЫ ДОТОР
26	ATR	АТАР ӨРГӨӨ	280.4	60.9	21.7%	350.0	2020.04.01	2020.07.31-НД ОЛГОВ
27	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	62.0	25.9	41.7%	1.0	2020.04.06	2020.06.29-НД ОЛГОВ
28	HUV	ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ	324.7	21.6	6.7%	150.0	2020.04.03	2020.05.01-ЭЭС
29	SUU	СҮҮ	5,668.0	1,715.1	30.3%	5.0	2020.03.27	2020.05.01-ЭЭС
30	HZB	ГАН ХЭРЛЭН	31.9	15.0	46.9%	150	2020.04.06	2020.09.30-НЫ ДОТОР
31	BTG	БАЯНТЭЭГ	2,166.2	500.0	23.1%	1,979.3	2020.02.07	2020.12.01-НИЙ ДОТОР
32	TTL	ТАВАН ТОЛГОЙ	48,062.7	43,238.0	90.0%	821.0	2020.04.03	2020.07.21-НД ОЛГОВ
33	ERS	МОНГОЛ АЛТ	71.3	39.9	55.9%	150.0	2020.04.29	2020.12.31-НИЙ ДОТОР
34	TEE	ТЭЭВЭР ДАРХАН	10.9	0.8	749.1%	500.0	2020.04.29	2020.12.31-НИЙ ДОТОР
35	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	530.2	65.1	12.3%	6.3	2020.09.09	2020.09.28-НД ОЛГОВ

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ



ОНЦЛОХ МЭДЭЭ

Анхны хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сан болох “Үндэсний хөрөнгө оруулалтын сан”-ийн анхдагч зах зээл дээр 2,245 хувь хүн, аж ахуйн нэгжийн нийт 5,537,565,300 төгрөгийн үнэт цаас худалдан авах санал ирсэн нь татан төвлөрүүлэх дүнгээс 16.5 хувиар давсан үзүүлэлт болсон.

Анхдагч зах зээлийн арилжаанд “Ард Секюритиз ҮЦК”, “БиДиСек ҮЦК”, “Ти Ди Би Капитал ҮЦК”, “Стандарт Инвестмент ҮЦК” болон “Голомт Капитал ҮЦК” хамгийн идэвхтэй оролцсон ба нийт арилжааны 94.7%-ийг эзэлсэн байна.

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

“Лэндмн ББСБ” /MSE: LEND/ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоол.

“Лэндмн ББСБ” /MSE: LEND/ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн (ТУЗ) хараат бус гишүүн Чинбат овогтой Номин нь 2020 оны 9-р сарын 22-ны өдөр ТУЗ-ийн хараат бус гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлт ирүүлсэн ба компанийн ТУЗ уг хүсэлтийг хүлээн авч 2020 оны 10-р сарын 21-ний өдрийн ТУЗ-ийн № 20/33 тогтоолоор тус гишүүний бүрэн эрхийг зогсоож, компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээс чөлөөлөх асуудлыг компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлэхээр болсон байна.

“Лэндмн ББСБ” /MSE: LEND/ ХК-ийн 3-р улирлын үйл ажиллагааны тайлан.

“Лэндмн ББСБ” /MSE: LEND/ ХК-аас 2020 оны III улирлын тайлангаа нийтэлсэн байна. Тайлант хугацаанд нийт 36.5 тэрбум төгрөгийн 172.4 мянган зээл олгосон байна. 2020 оны III улирлын зээлийн голлох үзүүлэлтүүдийг 2020 оны II улиралтай харьцуулахад олгосон зээлийн тоо 2.3 дахин өссөн, олгосон зээлийн үнийн дүн 2.1 дахин өссөн, зээлийн багц 4.5%-аар буурсан үзүүлэлттэй байна. COVID-19 цар тахлын нөлөөллөөс үүдэн 2020 оны I, II улиралд зээл олголтыг багасгаж хэрэглэгчдийг дахин скоринг хийж эхэлсэн байсан бол 2020 оны III улиралд бүх хэрэглэгчдээ дахин скоринг хийж дууссан ба зээл олголтыг үе шаттайгаар буцаан нэмэгдүүлж байгаа юм.

“Эрдэнэ ресурс девелопмент корпораци” /TSX: ERD, MSE: ERDN/ ХК-ийн нь Хар Морь талбайн анхан шатны өрөмдлөгөөр өндөр агуулга бүхий алтны эрдэсжилт огтоллоо.

“Эрдэнэ ресурс девелопмент корпораци” /TSX: ERD, MSE: ERDN/ ХК-ийн (“Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани”) Хөндий Алтны Дүүрэгт гүйцэтгэх 18,000 тууш метр өрөмдлөгийн анхан шатны хөтөлбөрийн хүрээнд Хар Морь талбайн хайгуулын үр дүнг танилцуулж байгаадаа таатай байна. Компани нь өнөөгийн байдлаар 10,000 тууш метрийн 1-р үе

шатны өрөмдлөгийн 3,600 метрийн сорьцлолтын үр дүнг хүлээн аваад байна.

Онцлох мэдээ:

- 2019 оны 4-р улиралд нээн илрүүлсэн, Баян Хөндий алтны ордоос хойд зүгт 3.5 км зайд байрлах, компанийн 100 хувийн эзэмшлийн Хар Морь хэтийн төлөв бүхий талбайд 11 цооног (1,574 тууш метр) өрөмдөн хайгуулын хөтөлбөрийг гүйцэтгэлээ.
- Газрын гадаргаас 30 метрийн босоо гүнд, хоёр цооногт алтны өндөр агуулга огтлогдсон.
 1. AAD-48 - газрын гадаргаас 27 метрийн гүнээс эхлэх алтны өндөр аномаль бүхий 7 метрийн бүсэд (0.2 г/т хүртэл) 30.6 г/т алтны агуулга бүхий 1 метр интервал огтолсон.
 2. AAD-48 цооногоос зүүн зүгт 1.25 км зайд KMT-03 сувгийн доор 29 метрийн босоо гүнд AAD-41 цооногт 10.8 г/т алтны агуулгатай 1 метрийн интервалыг огтолсон.
- Бүх цооногуудад алтны аномаль агуулга болон/эсвэл индикатор элементүүд (As, Mo, Sb)-ийн агуулга бүхий өргөн бүсүүд огтлогдсон.
- Алтны эрдэсжилт нь Баян Хөндий төслийнхтэй төстэй кварц-адулярын эпитеpmаль судалтай холбоотой бөгөөд гүндээ нээлттэй ба 1.5 км урт суналтайгаар зураглагдсан.
 1. Тайлагдсан судлын суналын урт нь чулуун дээжлэлт, геологийн зураглал, геофизикийн өгөгдлийн тайлал болон өрөмдлөгийн үр дүнд үндэслэгдсэн.
- Өрөмдлөгөөр алтны эрдэсжилт нь зүүн хойш чиглэлтэй структур, түүний салбаруудыг дагасан соронзон нам болон хөрсөн дэх алтны аномалиудтай холбоотой болохыг баталсан.
- Хар Морь талбайд төлөвлөсөн 2-р шатны өрөмдлөгийн хөтөлбөрийг 11-р сарын эхэнд төлөвлөсөн.

Эх сурвалж: Эрдэнэ ресурс девелопмент корпораци

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

Монгол Улсын уул уурхайн салбарын орлого нэмэгдэж байгаа ч түүнээс хуримтлал үүсгэж чадахгүй, улс төрийн популист хөтөлбөрүүдэд зарцуулж байгаад судлаач нар шүүмжлэлтэй хандаж байна.

2021 оны төсвийн төсөлд уул уурхайн салбарын орлогыг анх удаа 3.4 их наяд төгрөгт хүргэхээр тооцоолсон нь төсвийн нийт орлогын 26 орчим хувь юм. Харин Ирээдүйн өв санд уул уурхайн салбараас 1.2 их наяд төгрөгийн орлого төвлөрүүлэхээр тооцоолжээ. Энэ нь 2020 оны төсвийн тодотголд тусгасантай харьцуулахад 27 хувиар илүү байна.

1.2 их наяд төгрөгөөс уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн төрийн эзэмшилд ногдох хувьцааны ногдол ашгийн орлогоор 155 тэрбум төгрөг, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр 990.1 тэрбум төгрөг, хүүгийн орлогоор 35 тэрбум төгрөгийг бүрдүүлэх юм байна. Үүнээс гадна ирэх онд зэсийн зах зээлийн үнэ 6500 ам.доллар буюу тэнцвэржүүлсэн үнээс 19 орчим хувиар их байх төлөвтэй байгаа аж. Тиймээс 2021 онд зэсийн орлогоос төсвийн тогтворжуулсан санд 100.8 тэрбум төгрөг, нүүрсний орлогоос 55.2 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр тооцоолжээ. Хэдий тийм боловч Монгол Улс уул уурхайгаас олсон баялгаа хангалттай хуримтлуулж чадахгүй байгаад судлаач нар шүүмжлэлттэй хандсаар байна.

Эх сурвалж: BloombergTV.mn

МАКРО ЭДИЙН ЗАСАГ



Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийн журамд өөрчлөлт орж, 2020 оны 10-р сарын 1-ний өдрөөс өмнө авсан зээлийн жилийн хүүг 8 хувь, 2020 оны 10-р сарын 1-ний өдрөөс эхлэн авах зээлийн жилийн хүүг 6 хувь байхаар тогтоосон. Уг шинэчлэгдсэн журам хэрэгжиж эхэлсэн өдрөөс хойш 10-р сарын 22-ны өдрийн байдлаар нийт 15.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 221 иргэнд олгоод байна. Тус санхүүжилтийн 9.9 тэрбум төгрөгийн эх үүсвэр бүхий 157 хүсэлтийг Монголбанкнаас, 5.9 тэрбум төгрөгийн 64 хүсэлтийг арилжааны банкуудаас тус тус биелүүлэв.

Эх сурвалж: Монголбанк

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

БНХАУ-ын гангийн болон коксын үйлдвэрүүд Канадын өндөр чанартай коксжих нүүрсийг худалдан авахаар сонирхож эхэллээ.

Лхагва гарагт Канадын "Elkview"-ийн коксжих нүүрсийг тонныг нь 135-137 ам.доллараар худалдан авах хоёр хэлэлцээр байгуулсан байна. Эдгээр нь 12-р сард нийлүүлэгдэнэ гэж "SXCoal" мэдээлжээ. Үнийн хувьд Австралийн нүүрснээс 8 орчим хувиар өндөр дүнтэй аж. Мөн Канадаас тээвэрлэх коксжих нүүрсний хэмжээ Австралийнхаас өндөр байгааг эх сурвалж мэдээлж байна.

Канадын "Elkview" уурхайн 95%-ийг тус улсын "Teck Resources" компани эзэмшдэг аж. Хэдийгээр БНХАУ руу чиглэх экспорт эрс нэмэгдэхээр байгаа ч ирэх оны эхээр Австралийн нийлүүлэлт тогтвортой болно гэж тус компани үзэж байна.

Эх сурвалж: BloombergTV.mn




ШИНЖЭЭЧИЙН БУЛАН

ХААЛТТАЙ БОНДЫН СУДАЛГАА


2019 оны 1-р сараас 2020 оны 9-р сарын 31-ний өдрийг хүртэл үнэт цаасны компаниуд дотоодын зах зээл дээр нийт 56 удаа төгрөгийн хаалттай бонд гаргасан байгаагаас 69.6% буюу 39 хаалттай бонд 12 сарын хугацаатай байна (зураг 1).

Харин үнийн дүнгээр, зах зээлд нийт 60.9 тэрбум төгрөгийн хаалттай бонд нийлүүлснээс 73.6% нь 12 сарын хугацаатай, 17.5 хувь нь 24 сарын хугацаатай, бусад хугацаатай бонд 8.9%-ийг тус тус эзэлж байна (зураг 2).



Өгөөжийн хувьд, 6 сарын хугацаатай гарсан 3 хаалттай бондын хамгийн бага хүү 15.0%, хамгийн өндөр хүү 22.0%, дундаж хүүний түвшин 18.7% байна. Мөн 12 сарын хугацаатай гарсан 39 бонд 16.0%-21.0%-ийн хүүтэй байгаа ба тэдгээрийн хүүгийн дундаж түвшин 18.2%-тай тэнцжээ. Дэлгэрэнгүйг зураг 3-аас харна уу.

Зураг 3. Хаалттай бондын хүүний түвшин, гарсан бондын тоо ширхэг




ШИНЖЭЭЧИЙН БУЛАН

ХААЛТТАЙ БОНДЫН СУДАЛГАА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хаалттай бондын хүүгийн түвшнийг банкуудын зарласан зээлийн дундаж хүү, 5 том банкны хадгаламжийн хүүтэй харьцуулахад, бондын хүү зээлийн хүүгээс дунджаар 7.2 нэгж хувиар бага, хадгаламжийн хүүгээс дунджаар 3.5 нэгж хувиар өндөр байна.

Зураг 4. 2020 оны 9-р сарын байдлаарх хүүний түвшний харьцуулалт



МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.